



ДУНДГОВЬ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны 04 сарын 02 өдөр

Дугаар 32

Мандагговь

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг: Аймгийн Засаг даргын тамгын газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 107,164,813.25 (нэг зуун долоон сая нэг зуун жаран дөрвөн мянга найман зуун арван гурван төгрөг хорин тав) мөнгөний балансын үнэ бүхий Хүүхэд залуучуудын хөгжлийн төвийн барилгыг эзэмшил газрын хамт Шүүхийн шинжилгээний албанд балансаас балансад шилжүүлсүгэй.

Хоёр: Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга Ц.Эрдэнэсүрэн, аймгийн Шүүхийн шинжилгээний албаны дарга Б.Нарантуул нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай. Үүнд:

- 2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;
- 2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;
- 2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 04-р сард багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

Гурав: Энэхүү тогтоол гарсантай холбогдож 2019 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 01 дүгээр тогтоолд өөрчлөлт орсонд тооцсугай.

Дөрөв: Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.СҮХБААТАР



480219070